

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
/Жилийн эцсийн байдлаар/**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолд тусгуулж, Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлэх; Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулах зорилтын хүрээнд нийт 28 арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээний 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон тайлангийн хавсралтыг 4 дүгээр хүснэгтийн дагуу боловсруулав. Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын долоо дугаар бүлэгт заасныг баримталлаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан”-г нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилт хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Үнэлгээний тайланг ХХААХҮЯ-ны ТНБД-ын хурлаар арга хэмжээ тус бүрээр урьдчилан хэлэлцүүлж, гүйцэтгэлийн тайлагналтыг сайжруулах үүрэг даалгавар өгүүлснээр тайлагийн чанар дээшилж, үнэлгээнд өөрчлөлт оров. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж үнэлгээ, %
			100	70	40	0	(-)	
- Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ - Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ	2	28	13	10	5	-	-	78.6

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 78.6 хувьтай үнэлэгдэв. Үүнд: 13 арга хэмжээ “үр дүнтэй”, 10 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 5 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн бол “үр дүнгүй” эсвэл үнэлэх боломжгүй арга хэмжээ байхгүй.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

		Газар, хэлтэс								
		НТ Г	МААХ БЗГ	ГТХБ ЗГ	ХөҮХ БЗГ	ЖДҮҮ ХХБЗГ	ХүҮХ БЗГ	МГН Х	ХУХҮ СХ	МЭЕ Г
Үүнээс	Бүгд	1	5	9	3	2	2	2	2	2
	100%	-	3	2	-	2	2	-	2	2
	70%	1	1	4	1	-	-	2	-	-
	40%	-	1	3	2	-	-	-	-	-
	0%	-	-	-	-	-	-	-	-	-
	Үнэлэх боломжгүй	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэлгээ	70.0	82.0	66.7	50.0	100.0	100.0	70.0	100.0	100.0	

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар 1 арга хэмжээг 70.0, Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 5 арга хэмжээг 82.0, Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 9 арга хэмжээг 66.7, Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 3 арга хэмжээг 50.0, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлого, зохицуулалтын газар 2 арга хэмжээг 100.0, Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын 2 арга хэмжээг 100.0, Малын генетик, нөөцийн хэлтэс 2 арга хэмжээг 70.0, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтэс 2 арга хэмжээг 100.0, Мал эмнэлэгийн ерөнхий газар 2 арга хэмжээг 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 78.6 хувьтай үнэлэгдэв.

2. Доор дурдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу “40” үнэлгээтэй байв. Үүнд:

4.2. Өвөл, зуны хүлэмжийн нэмэгдэх талбай, га (ГТХБЗГ)

4.3. Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах, барилгын ажлын явц, хувиар (ГТХБЗГ)

4.4.4. Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн тариалалтыг дэмжих, алслагдсан бүс нутагт шинээр элеватор байгуулах ажлын явц, хувиар (ГТХБЗГ)

4.5. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх (ХөҮХБЗГ)

4.8. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах, ажлын явц, хувиар (ХөҮХБЗГ)

3. Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” журмын дагуу жагсаалтын ангиллын хүрээнд мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг тайлагнахгүй байгаагаас санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын ангилал тодорхой бус байна.

4. Мал, амьтны өвчний гаралт, вакцинжуулалтын арга хэмжээний гүйцэтгэл зэрэг мэдээллийг цаг тухай бүрт шууд авах боломжтой /цахим технологийн шийдэл, мэдээллийн сангийн програм

ашиглах гэх мэтээр/болгох шаардлагатай. Мэдээ, мэдээллийг бүтэн улирлаар хоцорч авч байгаа нь үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд учир дутагдалтайгаас гадна босоо удирдлага, тогтолцоотой байгууллагын хувьд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг арга хэмжээ бодитой хэрэгжиж байгаа гэж үнэлэхэд учир дутагдалтай байна.

Тав. Зөвлөмж

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгах ХХААХҮ-ийн салбарын зорилт, арга хэмжээний төсөл боловсруулахдаа дээр дурдсан нөхцөл байдал, эрсдэлийг тооцож тусгах, шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам баримтлан нарийвчлан тогтоох, өмнөх жилүүдэд хэрэгжилт хангалтгүй, яамны үнэлгээнд сөрөг нөлөөлсөн зорилт, арга хэмжээг тусгахгүй байхыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт;

2. Вакцинжуулалтын мэдээг Засгийн газрын 2018 оны “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 225 дугаар тогтоолд заасан ангиллын дагуу боловсруулж тайлагнаж байхыг Мал эмнэлгийн ерөнхий газарт;

3. Мал эмнэлгийн үйлчилгээний мэдээллийг цаг тухайд нь шуурхай авч байх мэдээллийн сангийн тогтолцоо бүрдүүлэхийг Мал эмнэлгийн ерөнхий газарт ;

4. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаал, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу тайлагнаж байхыг бүх газар, хэлтэст тус тус зөвлөж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН (жилийн эцсийн байдлаар)

97	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2019 онд хүрэх түвшин, үр дүн	2019 онд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/		Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
					Төлөв-н /тэрбум төг/	Гүйц-н /тэрбум төг/		
1	2	3	4	5	6	7		
ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО								
Зорилт 3.Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.								
3.1	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /цаашид “ТХХААТББ” гэх/-ын 4.1.13 дахь заалт, ЗГҮАХ-ийн 1.23, 2.20, 2.23, 2.48 дахь заалт,	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох БТГ	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо /Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хууль, Хоршооны тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль/	3	-	0.015	1. Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг зөвлөхөөр гүйцэтгүүлж, ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/4565 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А-503 дугаар тушаалын дагуу Зохицуулах үйлчилгээний хүнсний тухай хуулийн төслийг зөвлөхөөр гүйцэтгүүлж, ажил хүлээн авах комиссын актаар хүлээн авсан. 2. Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа, ажлын хэсэг болон олон нийтийн хэлэлцүүлгийг хийж гүйцэтгэв. УИХ-аар хэлэлцүүлэх эсэх талаар УИХ-ын ЭЗБХ-ны 2019.11.20 өдрийн хурал, УИХ-ын 2019.11.22, 2019.11.28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн 58,6%-аар дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлсэн. 3. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	70

3.2	ЗГҮАХ-ийн дахь заалт 2.25	Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх, мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, түүний техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх МҮББХЗГ	Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх сум, дүүргийн тоо	339	37.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	0.3977 (Нийт 397,7 сая төгрөг. Үүнээс Улсын төсөв: 289,5 сая төгрөг. Гадаад төсөл: 40873 USA \$ буюу 108.3 сая төгрөг)	Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлын хүрээнд улсын төсөв болон төслийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. 1.ХХААХҮ-ийн Сайдын тушаалаар А-133 дугаар тушаалаар 14 аймгийн 248 сумын 536,0 мянган малд төлөв байдлыг үнэлэх, тодорхойлох ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, мал үржүүлэг технологийн хавар, намрын технологит хугацаанд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 31 нэгжийн хүрээнд 43 ажлын хэсгийн 220 мэргэжилтэн мал сүрэгт төлөв байдлын үнэлгээг хийж гүйцэтгэв. 2. НҮБ-ын ХХААБ-ын “Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэхэд дэмжлэг үзүүлэх нь” техник туслалцааны төслийн хүрээнд ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал зүйч үржүүлэгчдийн холбоо ТББ, 21 аймаг, нийслэлийн ХХААГ-ын Мал үржлийн албаны дарга нарт 50 малзүйчдэд мэргэжил, арга зүйн сургалтыг зохион байгуулав. Мөн төслийн хүрээнд мэргэшсэн шинжээч малзүйчдийн багтай хамтран “Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх арга зүй эзэмшүүлэх” сургалтыг 21 аймаг, нийслэлийн Мал үржлийн алба, 332 сум, 6 дүүргийн Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг технологийн хувийн нэгжийн 420 мал зүйч мэргэжилтнийг хамруулан орон нутагт нь зохион байгууллаа. 3. Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ, үр дүн, тайланг мэргэшсэн шинжээчийн багийн 12 зөвлөх мал зүйчтэй хамтран гаргаж, цаашид авах арга хэмжээний саналыг 7 багц болгон нэгтгэж, үүний хүрээнд зах зээлийн эрэлтэд мал аж ахуйн салбарын бүтээмжит чадварыг нийцүүлэх, мал, малын гаралтай бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг түргэсгэх арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх боломж нээгдэж байна гэсэн дүгнэлтийг гаргасан болно. Мөн төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг төрийн бодлогоор тогтоож, ашиг шимийн чиглэлээр сонгон үржүүлэх, генетик нөөцийг бататган сайжруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч ажиллаж байна.	70
-----	---------------------------	--	--	-----	------------------------------------	--	--	----

			Мэдээллийн онлайн системийг бүрдүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх сум, дүүргийн тоо	339		0.06 (Улсын төсөв 69,9 сая төгрөг)	1.ХХААХҮ-ийн Сайдын А-163 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үржилд ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч малыг ялган тэмдэглэх, малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг 7 аймаг, нийслэлийн мал бүхий дүүргийн 3 дүүргийн нийт 95,7 мянган малд гүйцэтгэхээр ХХААГ-тай гэрээ байгуулж, 10,2 мянган бух, 28,2 мянган хуц, 17,2 мянган ухна, 8,1 мянган үнээ, 23,0 мянган эм хонь, 9,0 мянган эм ямаа , нийт 95,9 мянган малыг ялган тэмдэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байна. 2.мал эмнэлэгийн ерөнхий газрын 2019 оны төлөвлөгөөний хүрээнд Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн гоц халдварт өвчингүй, эрүүл бүсэд хамаарах Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх дүүрэгт үржүүлж буй 35.0 мянган үхрийг ялган тэмдэглэж, мал эмнэлгийн цахим сүлжээнд бүртгэх ажлыг зохион байгуулав. 3.Малын удмын сангийн үндэсний төвийн харьяа орон нутгийн салбар 11 цөм сүргийн үржлийн төвийн бүртгэлд хамрагдаагүй нийт 9223 мянган малыг ялган тэмдэглэгээ хийж тус төвөөс 9,9 сая төгрөгт зарцуулав. 4. ХХААХҮЯ, Францын Мал аж ахуйн хүрээлэн хамтран хэрэгжүүлэх “Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх” /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд төсөл хэрэгжиж буй Өвөрхангай аймгийн Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумдын нийт 190.0 мянган малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэхээр төлөвлөв.	70
3.3	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх МЭЕГ	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/	61	30.7 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	30.55 (Улс болон орон нутгийн төсөв 30,550.00 сая төгрөг.)	Шүлхий өвчний эрсдэлтэй нийт 9 аймгийн 118 суманд 2 удаагийн давталттайгаар нийт 22,7 сая толгой малыг дархлаажуулалтад хамруулж, нийт 3,5 тэрбум төгрөг, Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дахлаажуулалтад эрсдэл бүхий зүүн бүсийн 5 аймгийн 57 сумын нийт 5,8 сая толгой мал хамруулж, нийт 796,5 сая төгрөг, Хонины цэцгээс сэргийлэх дархлаажуулалтад зүүн бүсийн 5 аймгийн 62 сумын нийт 2,9 сая толгой хонь, хурга хамруулж, нийт 427,1 сая төгрөгийн	100

						санхүүжилтийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгоод байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар гоц халдварт өвчний хорио цээртэй аймаг, сум байхгүй ба гоц халдварт өвчний гаралтыг 2018 оны 06 дугаар сартай харьцуулахад шүлхий-90, бог малын мялзан 80 хувиар буурсан бол хонины цэцгийн гаралт буураагүй байна. Монгол улсын 21 аймаг, нийслэлд нийт 18 нэрийн халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 22,48 сая толгой мал, бруцеллэз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 15,21 сая толгой мал хамруулсан. Халдварт, гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 60,39 сая толгой мал хамруулсан.	
			Вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга	200	3.3—тай 1 төсөвтэй	Шүлхий өвчний вакцины дархлаа шалгах тандалт шинжилгээнд ОХУ-ын тосон хүчлүүрт шүлхийн О, А хэвшлийн вакцин таригдсан 9 аймаг, нийслэлийн мал сүрэгт вакцин таригдсанаас хойш төлөөлөл болгон 4950 ийлдсийн дээжийг шинжилсэн. Вакцин тарснаас хойш 21 дэх хоногт тогтсон дархлаа О хэвшилд 84.8, А хэвшилд 85.7 хувьтай гарсан байна. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцин 2018 онд таригдсан зүүн бүсийн 5 аймгийн 34 сумын 65 багийн 355 өрхийн нийт 7100 малын ийлдсийн дээжинд хийгдсэн шинжилгээгээр Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймгуудын дунджаар 66.3 хувьтай байна. Бруцеллэз өвчний халдвар илрүүлэх тандалтад 21 аймгийн нийт 294.1 мянган толгой мал хамруулж, 79.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, 2019 оны 10 дугаар сарын байдлаар бруцеллэз өвчний халдварын төвшин 0.26 хувьтай байна. Өмнөговь аймгийг бруцеллэз өвчний халдвар илрүүлэх тандалтад хамруулаагүй бол Говь-Алтай аймагт бруцеллэзын халдвар илрээгүй байна. Бруцеллэзын вакцины дархлаа шалгах тандалтад 8 аймгийн 16 сумын нийт 9228 мянган толгой хамруулж, 85.4 хувийн дархлаа тогтсон байна.	100

3.4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.38 дахь заалт	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах МААБХЗГ	Цэвэр үхрийн өсөлт, толгой	үүлдрийн тооны мянган	5	20.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшил	Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019-2023 оны төлөвлөгөө 2019 онд тус тус батлагдсан. Төлөвлөгөөнд хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах арга хэмжээнүүд, тухайлбал өвлийн улирлын шингэн сүүний урамшуулалд 2.0 тэрбум олгох, зуны улирлын сүү боловсруулах технологийг сайжруулахад зээлийн дэмжлэг үзүүлэх ажлууд тусгагдсан. Эдгээр арга хэмжээний үр дүнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн. -Беларусь улсын хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр 2019 онд сүүний чиглэлийн хар тарлан үүлдрийн 1300 толгой хээлтэй гунжийг импортлон газар тариалан, тэжээлийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг түшиглэн 200 болон 300 үнээний цогцолбор ферм байгуулах тухай гэрээ, хэлэлцээр хийгдсэн. -Цэвэр үүлдрийн үхрийн аж ахуй эрхэлдэг "Нүүдэлчин" ХХК нь 2019 оны эхний хагаст 3 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар 20 үнээний 2 кластер ферм байгуулсан байна. -Азийн Хөгжлийн банкны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хөрөнгөөр Швейцарь улсаас сүүний чиглэлийн "Голштейн" (Хар тарлан), "Симменталь", мах-сүүний чиглэлийн "Brown Swiss", "Original Brounvieh", "Ангус" Улаан, махны чиглэлийн "Лиммузин" үүлдрийн өндөр ашиг шимт хүйс жолоодсон 1200 тун охин үр, 12.8 мянган тун гүн хөлдөөсөн үр, нийт 14.0 мянган тун үрийг 620.2 сая төгрөгийн /234.5 мянган ам доллар/ хөрөнгөөр худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэж өгсөн. -ЖДҮХС-аас 2019 онд сүү, махны үхрийн аж ахуйг өргөтгөхөд зориулж 40 төсөлд 3.8 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр 292 хүнд шинээр ажлын байр бий болов. -Дархан-Уул аймаг орон нутгийн төсөвтөө Үхрийн аж ахуйн суурьшлын бүс байгуулахад шаардлагатай 500 сая төгрөгийг тусгаж Булган аймгаас Сэлэнгэ үүлдрийн 100 толгой хээлтэгч худалдан авах бэлтгэл ажлыг хангасан байна..	100
-----	---	---	----------------------------	-----------------------	---	---	--	-----

			Гахай, тахианы аж ахуйн тооны өсөлт, хувиар	4 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 6.0 тэрбум төгрөгөөр гахай, шувууны аж ахуйд хийгдсэн байна.		-ЖДҮХС-гаас олгох зээлийн 25 хувийг ЭМАА-д олгох талаар ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн шийдвэр гаргуулав. Ингэснээр гахай, тахианы аж ахуйг дэмжих, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн. -2019 оны эхний хагас жилийн байдлаар 845 өрх, аж ахуйн нэгжид 29.4 мянган гахай, 1176 өрх, аж ахуйн нэгжид 1.2 сая өндөглөгч тахиа байгаа нь тахианы тоо 2018 оны түвшингээс 33.0 хувиар өсч, харин гахайн тоо өсөөгүй байна. -Улсын төсвөөс шувууны аж ахуйд дэмжлэг үзүүлэхгүй байгаагаас орон нутаг дахь жижиг аж ахуйнуудын тоо цөөрч байна. Харин "Түмэн шувуут" ХК бонд гарган үйл ажиллагаагаа өргөтгөн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 120.0 мянган шувууны 3 байрыг шинээр ашиглалтад оруулж Био иодтой өндөг, Омега-3 агууламж өндөртэй өндөг зэрэг "бренд бүтээгдэхүүн"- ийг үйлдвэрлэж эхэлсэн байна. - "Зургаан хошуу" ХХК Дани улсаас цэвэр үүлдрийн 1000 мэгж, 50 бодон худалдан авах гэрээ байгуулж санхүүжилт дутагдсанаас манай яаманд 2.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн төсөл боловсруулж ирүүлснийг дэмжиж санхүүжилт олгох талаар санал боловсруулж байна. Уг аж ахуйн нэгж нь фермээ Дани улсын технологиор засварлан гахай хүлээн авах байрыг засварлахад 1.5 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт хийсэн. Гахай худалдан авах санхүүжилт шийдэгдсэн нөхцөлд манай орны гахайн аж ахуйн үйл ажиллагаагаа хэвийн явуулах бүрэн боломжтой	70
Зарим бүтээгдэхүүний импортыг бууруулах хувь:							
			-Тахианы өндөг Зарцуулсан хөрөнгө 0	13.0		- ЭМАА-н хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд шувууны аж ахуйн арчилгаа маллагаа, технологийн түвшин, эрчимжүүлэлтийг сайжруулах, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхэй нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндөгний хувийг бууруулах талаар тусгав. - 2017 оны жилийн эцсийн өндөглөгч тахианы тоо толгойг 2018 онтой харьцуулахад 300 гаруй мянган толгой буюу 30 гаруй	40

						хувиар нэмэгдэж байгаа нь өндөгний импортыг 13 хувиар бууруулах бүрэн боломжтой гэж үзэсэн. Харин 2018 онд 135.8 сая ширхэг өндөг, 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 147.1 сая ширхэг өндөг импортолж өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 11.3 сая ширхэг өндөгөөр өссөн дүн гарчээ.	
			-Зөгийн бал	18.0 Төсөл, хөтөлбөр: 802.9 сая төгрөг		-Зөгийн аж ахуйн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологийн түвшин, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэж, зорилтот зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэн, импортын зөгийн балыг 2023 онд 70.0 хувиар бууруулахаар ЭМАА-н хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан. - "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" төслийн хүрээнд 215.5 сая төгрөгийн хөрөнгөөр ХААИС-ийн Мал аж ахуй биотехнологийн сургууль, Улсын мал эмнэлгийн төв лаборатори, Мал эмнэлэгийн хүрээлэнд нийт 34 нэр төрлийн зөгийн балаар эм болон уурагт тэжээл үйлдвэрлэх зориулалт бүхий багаж, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч дээрх байгууллагуудын үйлдвэрлэлийн болон оюуны чадавхийг сайжруулах арга хэмжээ хэрэгжсэн. -Мөн төслийн 347.4 сая төгрөгийн хөрөнгөөр зөгийн гэр 600 ширхэг, зөгийн сэмж 268 боодлыг худалдан авч Дархан-Уул, Булган, Орхон, Хэнтий, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын 26 хоршооны үйл ажиллагааг дэмжиж ажилласан. -Япон улсын ЖАЙКА-байгууллагатай хамтран Өвсний үндэс, техникийн хамтын ажиллагааны хүрээнд “Зөгийн аж ахуйн хөгжлийг дэмжих замаар орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх” төсөл Дархан, Сэлэнгэ аймагт хэрэгжиж Зөгийн балны үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, зөгийчдийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулав. -2019 онд ЖДҮХС-аас зөгийн аж ахуйг өргөтгөх 2 төсөлд 240.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв.	100

			-Хүчит гэжээл	11.0 0,665 ЖДҮХС-аас 2019 онд малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчлэх, бага оврын тэжээлийн үйлдвэр шинээр барих зэрэг 6 ААН-д 665.0 сая төгрөгийн зээл олгосон байна.			2019 онд Улаанбаатар хотод протейн тэжээлийн үйлдвэр ашиглалтанд орсон. Тус үйлдвэр өдөрт малын гаралтай 96 тонн хаягдал түүхий эд боловсруулж 24 тонн тэжээлийн уураг, малын гаралтай 17 тонн тос үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. -Манай улс жилд 18 орчим тэрбум төгрөгийн тэжээлийн уургийг импортоор авдаг. Гахай, тахианы эрчимжсэн аж ахуйн тэжээлийн уургийн 80 хувийг дангаараа хангах хүчин чадалтай энэ үйлдвэр ашиглалтад орсноор импортыг бууруулах бодит боломжийг бүрдүүлсэн. Уг тэжээлийн үйлдвэр нь импортын тэжээлийн 8.8 хувийг хангана. Мөн “Баялаг феед” ХХК нь үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж өнжсөн өвсийг сүүлийн үеийн дэвшилтэд аргаар уураг өндөртэй 2000 тн тэжээл үйлдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. -Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Тэжээлийн тогтвортой менежмент” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг төсөл нь импортоор орж ирдэг тэжээлийн түүхий эдийг монголд тариалах, нутагшуулах, тэжээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Төсөл хэрэгжснээр импортын тэжээлийн түүхий эдийг дотооддоо бэлтгэж, тэжээлийн импортыг бууруулна. -ЖДҮХС-аас 2019 онд малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчлэх, бага оврын тэжээлийн үйлдвэр шинээр барих зэрэг 6 аж ахуйн нэгжид 665.0 сая төгрөгийн зээл олгосон байна. -Гаалийн мэдээгээр 2018 оны 11 дүгээр сард 47.7 мянган тн хүчит тэжээл импортолж байсан бол 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 23.4 мянган тн хүчит тэжээл импортолж хүчит тэжээлийн импорт өмнөх жилээс 50.0 хувиар буурсан байна.	100
Зорилт 4.Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулна.								
4.1	МУТХҮБ-2030-ЫН 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34 дэх заалт	“Мах, сүүний анхдугаар аян”-ы хүрээнд үйлдвэр-ийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн аргаар боловсруулах махны хэмжээ, мянган тонн	24.6	25.3 Улсын төсөв	Зарцуулсан хөрөнгө 0	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ 2019 оны 11 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 29.7 мянган тн байна. Урьдчилсан байдлаар 120 хувийн гүйцэтгэлтэй байна.	100

			Үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээ, сая литр	85.0			Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2019 оны эхний 11 сарын урьдчилсан байдлаар 167.7 сая литр буюу хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн сүүний хэмжээтэй харьцуулахад 18.5 хувьтай байна. /2019 оны 12 сарын статистикийн мэдээ гараагүй байна. 2018 онд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү сүүн бүтээгдэхүүний хэмжээ 136.0 сая.литр болсон. Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 15% байна.	100
4.2	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ТХХААТББ-ын 3.1.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.39, 2.40, 2.45 дахь заалт	Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангалтыг нэмэгдүүлэх ГТБХЗГ	Өвөл, зуны хүлэмжийн нэмэгдэх талбай, га	10.0	5.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	0.69 Улс, орон нутгийн төсөв, ЖДҮДсан - 690.1 сая төгрөг	2018 онд нийлүүлсэн 171.0 сая төгрөгийн санхүүжилтээр 5120 м2 талбай бүхий 160 ширхэг нийлэг хальсан хүлэмжийг 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай зээлээр олгов. 2019 онд Орхон, Булган аймагт орон нутгийн төсвөөр 32м2 талбай бүхий нийт 130 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж, улсын төсвийн 147.0 сая төгрөгийн хөрөнгөөр 120 м2 талбай бүхий 38 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмжийг нийлүүлж хүлэмжийн талбайг 9560 м2-аар нэмэгдүүлэв. ЖДҮ-ийг дэмжих сангаас 2019 онд 372.1 сая төгрөгийн зээлийг өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах 4 төсөлд олгож хүлэмжийн талбайг 2000м2-аар нэмэгдүүлэв. БНСУ-ын Гангвон мужийн хөрөнгө оруулалтаар Төв аймагт 1000 м2 орчин үеийн дэвшилтэт технологийн давхар хүлэмж байгуулав. Дээрх арга хэмжээний үр дүнд хүлэмжийн талбай 1.8 га талбайгаар нэмэгдсэний зэрэгцээ хувийн хөрөнгө оруулалтаар 0.26 га хүлэмж шинээр байгуулагдаж нийт хүлэмжийн талбайн 2.1 га-аар нэмэгдсэн байна. Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Хөдөө аж ахуйг их сургуулийн дэргэд “Хүнсний ногооны хүлэмжийн жишиг агропарк, сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах” инновацийн төсөл хэрэгжүүлэх төрийн өмч давамгайлсан гарааны компани байгуулахаар шийдвэрлэв. Төслийн хүрээнд БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар 10 га талбай бүхий өвөл, зуны хүлэмж байгуулж жилд 600-800 тонн ургац хураан авахаар төлөвлөж байна.	40

			Өвөл, зуны хүлэмжээс хураан авах ургац, тонн	3500	10.0 Хөгжлийн банк	0.69 (690.1 сая төгрөг).	2019 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд өвөл, зуны хүлэмжнээс хураан авах ургац 1.0 мянган орчим тонноор нэмэгдэж улсын хэмжээнд жилд 6700 тн хүнсний ногоо хураан авах боломжтой болов.	70
			Нэмэгдэх зоорийн багтаамж, тонн	2000	2.6 Улсын төсөв	1.45 (1,450.0 сая төгрөг)	Улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Ховд, Сүхбаатар аймагт нийт 1500 тн-ын багтаамжтай төмс, хүнсний ногоо хадгалах зорь байгуулахаар ажиллаж байна. Ховд аймгийн зоорийг 2018-2019 онд байгуулж дуусгах гэрээг МГБИ ХХК-тай байгуулсан. Сүхбаатар аймгийн зоорийн ажил дууссан. Ховд аймгийн зоорийн ажил дуусаагүй. 2020 онд дуусгахаар гэрээг сунгасан.	70
			Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх хувь	5.0	5.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	7.47 БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн 97.8 мянган ам.долларын 1 га-н төмс, хүнсний ногооны бороожуулагч 80 ширхэг, 258.8 мянган ам.долларын 10 га-аас дээш талбайг услах хүчин чадал бүхий дунд оврын дамартай бороожуулагч 18 ширхэг, 470.0 сая төгрөгт 57 ширхэг техник, тоног төхөөрөж, Улсын	2019 онд төмс 13.8 мянган га-д тарьж 170 мянган тн, хүнсний ногоо 8.3 мянган га-д тарьж 102.7 мянган тн ургац хураан авах зорилтыг аймгийн Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг хийв.Төмс 14.3 мян га-д тарьж 190.8 мянган тн, хүнсний ногоо 8.3 мянган га-д тарьж 98.6 мянган тн хураан авч төмс 100 хувь, ногооны хэрэгцээг 40 хувь хангасан. Ил талбайн 3 нэр төрөл 1875.3 кг үр, хүлэмжийн 3 нэр төрлийн 21.5 кг ногооны үрийг хуулийн дагуу худалдан авч аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан 625 ногоочдод дэмжлэгээр олгов. 2019 онд туршсан ногооны 6 сортыг хэлэлцэж лоолийн жижиг жимстэй “Semini3 сорт, бөөрөнхий сонгины 4 сортыг сорилтод, гүзээлзгэний “Санта” сорт, цэсийн “Чёрный красавец”, ил талбайн хэмхийн “”Restina fl” сортуудыг ирээдүйтэй сортоор хэлэлцэн батлав. Хүнсний ногооны 1 га талбайг услах бага оврын бороожуулагч 80 ширхэг, 10 га-аас дээш талбайг услах хүчин чадалтай дунд оврын дамартай бороожуулагч 18 ширхэгийг авч ХХААХУ-ийн сайдын А-107 дугаар тушаалаар төмс, ногооны тариалан эрхлэшчдэд 8 жилийн хугацаатай жилийн 2 хувийн хүүтэй зээлээр олгож байна. Мөн ХХААХУ-ийн сайдын 2019 оны А-177 дугаар тушаалын дагуу ногоочдод түрээсийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 12 нэр төрлийн 57 ширхэг техник, тоног төхөөрөмж олгов.2018 оны А-119 дугаар тушаалаар батлагдсан	70

						төсвийн 100.0 сая төгрөгт хүнсний ногооны үрийн дэмжлэгийг хуулийн хүрээнд зохион байгуулав.	бордоо, үрлэгч, нийлэг хальсны хуваариар 2019 онд 78 тн органик бордоо, 152 ширхэг нийлэг хальс, 13 ширхэг хүнсний ногооны үрлэгчийг хүсэлт гаргаж, төлбөр төлсөн аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд хуваарилав.	
			Жимс, жимсгэнэ тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ, га	10	5.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	3.635 Улсын төсөв-1347.0 сая төгрөг Азийн хөгжлийн банк-1200.0 сая төгрөг АХБ зээл-1088.0 сая төгрөг	Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн “Чацаргана” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 107.0 сая төгрөгийн хөрөнгөөр органик шавж баригч наалтын цехийг нийлүүлж Ургамал хамгааллын хүрээлэнд суурилуулж органик жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. Мөн ШУТИС-ийн Техник, технологийн туршилтын төв дээр 945.3 сая төгрөгийн өртөгтэй Тайвань улсад үйлдвэрлэсэн “Нүүрсхүчлийн хийгээр хандлах аргаар чацарганы үрийн тосыг ялгах төхөөрөмж” суурилж хүлээлгэн өгөв. Үүний үр дүнд Монгол чацарганы үрийн тосыг нарийвчлан судалж чанарыг олон улсад баталгаажуулах, өндөр технологийн цэвэршилт сайтай чацарганы үрийн тосыг экспортлох боломжтой болов. АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Завхан аймгийн “Завхан баялаг” ХХК-д жимс жимсгэний тариалалт, боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд зориулан 1.088 тэрбум төгрөгийн 7 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгож үйлдвэрлэлийн технологийг сайжруулахад дэмжлэг үзүүлэв. 2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1.2 тэрбум төгрөг санхүүжилтээр Ховд аймгийн Булган, Жаргалант суманд жимс жимсгэний суулгац үржүүлгийн төвүүдийг байгуулж орон нутагт нутагшсан стандартын шаардлага хангасан суулгац үржүүлэх эхлэл тавигдав. Булган аймагт Шинэ хөдөө төслийн хүрээнд 7 суманд	70

							тус бүр 8 га талбай бүхий жимс жимсгэний дуслын усалгааны төхөөрөмж, суулгац, нийлэг хальсан нийлүүлж жимс жимсгэнэ, хүнсний ногооны тариалалтыг 56 га талбайгаар нэмэгдүүлэв. Улсын төсвийн хөрөнгөөр 120 м2 талбай бүхий 10 иж бүрдэл жимсний суулгац үржүүлгийн мананжуулагчтай хүлэмж нийлүүлж суулгац үйлдвэрлэлийг 200.0 мянган ширхэгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалагчдын улсын анхдугаар зөвлөгөөнийг 11 сарын 08 нд зохион байгуулж 22 аймаг нийслэлийн 400.0 гаруй төлөөлөгч оролцож ойрын хэрэгжүүлэх бодлого зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал бодлоо солилцов.	
			Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин, хувиар	50.0	Улсын төсөв, 7.0 Гадаад эх үүсвэр	7.0 БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө 2.7 сая ам. доллар буюу 7,000.0 сая төгрөг. Улсын төсвийн хөрөнгө 470.0 сая төгрөг	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ХХААХҮ-ийн сайдын 2019.06.05-ны өдрийн А-177 дугаар тушаалын дагуу ногоочдод түрээсийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн ХХААГ-т нийт 470.0 сая төгрөгийн үнэ бүхий 12 нэр төрлийн 57 ширхэг техник, тоног төхөөрөмж олгож 3 аймгийн 6 сумын 80 гаруй ногоочин өрхийн 100 га төмс, хүнсний ногооны талбайн ажлыг механикжуулав. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн 2.7 сая ам. долларын хөрөнгөөр хүнсний ногооны үйлдвэрлэлийн зориулалттай 120 ширхэг трактор, бууц, бордоо цацагч 41 ширхэгийг нийлүүлж ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-139 дүгээр тушаалын дагуу ТЭДС-аар дамжуулан ногоочдод 10 хувийн урьдчилгаатай 7 жилийн хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэй зээлээр олгох ажлыг зохион байгуулж байна. 2019 онд нийт 732.1 мянган ам. долларын үнэ бүхий 33 ширхэг трактор, техник тоног төхөөрөмжийг журмын дагуу зээлээр олгосон.	100
4.3	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт,	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс,	Барилгын ажлын явц, хувиар	80.0	59.0 Хөгжлийн банк	0.0233 23.3 сая төгрөг	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах зураг төсөлд магадлагаа хийлгүүлэх зөвлөх үйлчилгээний ажлыг “ХБХДТ” ХХК-аар хийлгэсэн.	40

	ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт	жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах ГТБХЗГ					ГЭЗҮ–д байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээг тэндерт шалгарсан “Санни трейд” ХХК, ГЭЗҮ-д үерийн уснаас хамгаалах, хөрсний усыг доошлуулах нэмэлт зураг төсөл хийх зөвлөх үйлчилгээг тендерт шалгарсан “Силвер Эделвэйз” ХХК-иуд тус тус гүйцэтгэсэн.	
4.4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт	Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн тариалалтыг дэмжих ГТБХЗГ	Хураан авах үр тарианы хэмжээ, мянган тонн	400	-	3.0 Улсын төсөв 3,000.0 сая төгрөг	2019 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 424.4 мянган тонн үр тариа, үүнээс 407.6 мянган тонн улаанбуудай, 190.8 мянган тонн төмс, 94.6 мянган тонн хүнсний ногоо, 35.2 мянган тонн тосны ургамал, 119.6 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 250.0 мянган тонн буудай нийлүүлэгдсэн байна.	100
			Тариалангийн талбайн загвар хашаа байгуулах хэмжээ, га	1000	18.0 Хувийн хөрөнгө оруулалт	3.0 3,000.0 сая төгрөг	2019 онд Улсын төсвийн 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Хонгор суманд 27 км, Дорнод аймгийн Халх гол суманд 45.0 км, Орхон аймгийн Жаргалант суманд 15.0 км, Төв аймгийн Жаргалант суманд 50.0 км, Борнуур суманд байрлах Хөдөө аж ахуйн их сургуулийн Судалгаа шинжилгээний Нарт төвд 4.07 км, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 40.0 км, Хүдэр суманд 10.0 км, Орхон туул суманд 30.0 км, Баруунбүрэн суманд 10.0 км, Хушаат суманд 10.0 км, Зүүнбүрэн суманд 20.0 км, Баянгол суманд 50.0 км, Хөвсгөл аймгийн Тариалан суманд 20.0 км, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хурх тосгонд 71.85 км, Биндэр суманд 21.0 км буюу нийт 423.9 км хашаа барих ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан. Орон нутаг дахь ажлын хэсгийн хашаа хүлээн авсан тухай актыг үндэслэн 10 аж ахуйн нэгжийн ерөнхий актыг үйлдэн гэрээг дүгнэсэн. Нийт 423.92 км хашаа барихаас 2019 онд 281.0 км хашааг бүрэн барьж дуусгасан ба 142.92 км хашааны бараа материалыг хашаа барих байршилд бүрэн нийлүүлсэн. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн ТНБД-ын тушаалаар 6 гэрээг сунгахаар шийдвэрлэж гэрээний дагуу гүйцэтгэх зарим ажлыг 2020 онд хүлээж авахаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.	100

			Усалгаатай талбайн хэмжээ, мянган га	55.6	4.7 Улсын төсөв	20.600 Улсын төсвөөр 1,200.0 сая төгрөг БНХАУ-ын зээл 19,400.0 сая төгрөг	Ховд аймгийн Зэрэг, Булган, Үенч, Буянт сумдын 4 усалтын системийг 1,2 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, сэргээн засварлаж усалгаатай тариалангийн эргэлтийн талбайн хэмжээг 767 га-аар нэмэгдүүлээд байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд 16.9 сая америк долларын үнэ бүхий 50-125 га талбайг услах үр тарианы зориулалттай усалгааны тоног төхөөрөмж 130 ширхэг, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг услах зориулалттай бага болон дунд оврын усалгааны тоног төхөөрөмж 126 ширхэг, 0.8-1.0 тра даралттай усалгааны хуванцар хоолойг тус тус худалдан авч усалгаатай тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид жилийн 2 хувийн хүүтэй 8-12 жилийн хугацаатай зээлийг Сайдын А-107, А-176 тоот тушаалаар ТЭДС-гаар дамжуулан зээлээр олгож эхлээд байна. Үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 13 аж ахуйн нэгж, 1 иргэнд 19.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий 35 ширхэг усалгааны тоног төхөөрөмжийг 12 жилийн хугацаатай зээлээр олгож усалгаатай тариалангийн эргэлтийн талбайг 3000 га-аар нэмэгдүүлснээр нийт 3767 га талбай шинээр ашиглалтанд орох боломж бүрдсэн.	100
			Алслагдсан бүс нутагт шинээр элеватор байгуулах ажлын явц, хувиар	80.0	13.2 Гадаад эх үүсвэр	0.047 47.0 сая төгрөгөөр ТЭЗҮ боловсруулсан.	ОХУ-ын Засгийн газрын зээлийн эх үүсвэрээр 200 тоннын 5 ширхэг, 300 тоннын 5 ширхэг, 500 тоннын 5 ширхэг босоо төмөр агуулах нийлүүлсэн. Босоо төмөр агуулахын багтаамжийг 6000 тонноор нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. ТЭДС Хөтөл салбарт 1000 тонн Сэлэнгэ салбарт 1000 тонн багтаамжтай хэвтээ агуулахыг байгуулж ашиглалтад оруулсан. Увс аймгийн Баруунтуруун, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд тус бүр 10.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах элеваторын ТЭЗҮ-ийг боловсруулав.	40
4.5	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, Төрөөс аж	“Үйлдвэржилт 21:100” үндэсний	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар		251.0 Гадаад эх үүсвэр,	30.259 Улсын төсөв-17,559.0	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А-07 дугаар тушаалаар "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийн төлөвлөгөө батлав. УИХ-ын 2019.06.06-	40

	<p>Үйлдвэрийн талаар баримтлах бодлого /цаашид “ТАУТББ” гэх/-ын 4.2.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.48, 2.50, 2.55, 2.56, 2.57 дахь заалт</p>	<p>хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх Хөнгөн ҮБХЗГ</p>		30	Хувийн хөрөнгө оруулалт	<p>/үүнээс:17,300 -ЖДҮХС-аас/ Гадаадын төсөл-12,700.0</p>	<p>ны өдрийн хурлаар “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”, Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдох бүхий салбарын жагсаалт, “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”, ХХААХҮ-ийн сайдын А-119 дүгээр тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам” тус тус баталж, хөнгөлөлттэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтыг орон даяар зохион байгуулав. Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлав. Үйлдвэржилт 21:100 Үндэсний хөтөлбөрийн хууль эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд: •Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор баталсан дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлав. Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж чанар, стандартын шаардлага хангасан 155 барааг дотоодын үйлдвэрээс хангахаар тусгасан. •Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газрын 343 дугаар тогтоолоор шинэчлэн батлав. Нийт 38 үйлдвэр үйл ажиллагаа явуулж эхэлсэн, 65 үйлдвэр 10-90 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 4000 орчим ажлын байр бий болсон байна.</p>	
4.6	<p>МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.48, 2.51 дэх заалт</p>	<p>“Ноолуур” хөтөлбөр хэрэгжүүлэх Хөнгөн ҮБХЗГ</p>	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20	22.6 Улсын төсөв	<p>116.43 Улсын төсөв 63.96 Монгол Улсын хөгжлийн банк 107,900.0</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилт 64.6 хувиар үнэлэгдэв. Зарим арга хэмжээг дурьдвал: УИХ-д өргөн баригдаад байгаа “Зөвшөөрлийн тухай” хуулийн төсөлд стратегийн түүхий эд болох ноолуурын үйлдвэрлэл, худалдааг тусгай зөвшөөрөлтэй болгох асуудлаар санал боловсруулж хүргүүлсэн. “Ямааны ноолуурын үйлдвэрлэл худалдаанд” мөрдөх техникийн зохицуулалтын төсөл болон холбогдох баримт бичгийг</p>	70

						Олон улсын төсөл, хөтөлбөр 970.0 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 7,500.0	<p>боловсруулж, ХХААХҮ-ийн Сайдын зөвлөл болон олон нийтээр хэлэлцүүлж, яамдуудаас санал авахаар хүргүүлэв. ШХА-ын “Ногоон алт-Малын эрүүл” мэнд төслөөс 7 аймгийн 22 сумын 3100 малчин, АХБ-ны “ХАА хөдөөгийн хөгжлийн техник тусалцаа”-ны төслөөс 4 аймгийн 18 хоршооны 578 малчин, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Тогтвортой ноолуур” төслөөс 2 аймгийн 6 хоршооны 400 малчинд ноос, ноолууран түүхий эдийг бэлтгэх чанарын сургалтыг зохион байгуулсан. Малчдаас бэлтгэсэн түүхий эдийг бүртгэлжүүлэх, чанарыг мөшгөх зорилгоор Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр 18 аймгийн 28 сумын хоршоо болон сумын бэлчээр ашиглагчдын холбоог мөшгөх тогтолцооны RMTS цахим системд оруулж эхлэв. ТНБД-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь ноолуурын салбарт шаардлагатай ээрэх үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг хийж, Япон, Итали зэрэг ээрэх технологи өндөр хөгжсөн улсаас хөрөнгө оруулалт татах чиглэлээр холбогдох уулзалтуудыг хийв. Мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ээрэх үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд суурилагдаж байна. “Монголын хаан ширхэгт” гэрчлэх тэмдгийг олгохтой холбогдсон бэлтгэл ажлууд хийгдэж байна. Ноолууран бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах зорилгоор АНУ, Япон зэрэг улсуудад үзэсгэлэн худалдаа, бизнес уулзалтуудыг зохион байгуулав. Ноолуурын үйлдвэрүүдэд аттестатчилал явуулах, салбарын мэргэжилтэй ажилтны судалгаа хийх ажлуудыг эхлүүлэхээр холбогдох баримт бичгийг боловсруулав. Ноолуур хөтөлбөрийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг хавсралтаар хүргүүлэв (2019 оны IV улирлын байдлаар).</p>	
4.7	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.50, 2.15, 2.54 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэрийг хөнгөлөлттэй зээлийн	Санхүүжүүлэх төслийн тоо	400-аас доошгүй	200.0 Улсын төсөв, гадаад эх үүсвэр	0.0912 улсын төсөв 47,444.0	1. 2019 оны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 47,0 тэрбум төгрөг батлагдаж үүнээс ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны А-41 тоот тушаалаар орон нутагт 20,5 тэрбум төгрөгийг хуваариллаа. Эх үүсвэрийг нэмэгдүүлэх	100

		бодлогоор дэмжих ЖДҮХБХЗГ				Сум хөгжүүлэх сан-10,500.0 Зээлийн батлан даалтын сан 33,298.0	хүрээнд Өмнөговь аймагтай хамтран ажиллаж 2,0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг нэмэлтээр бүрдүүлж тус аймгийн ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олголоо. ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ыг батлан төсөл сонгон шалгаруулалтанд 47,0 тэрбум төгрөгийн 4 зээлийн багцын хүрээнд нийт 452 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 5 жилийн хугацаатай 3,0-5,6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг олгох нөхцөл бүрдсэн. Энэ удаагийн хөнгөлөлттэй зээл олгох хүрээнд хүүг бууруулж, орон нутагт зориулсан зээлийн багцыг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлж, зээлдэгчдэд зээлийн эрсдэлийн даатгалын тогтолцоог бий болгож даатгалд хамруулж зээлийн нөхцөлийг сайжруулаа. 2. Сум хөгжүүлэх сангаас 2019 оны 04 дүгээр улирлын байдлаар 2620 төсөлд 10.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож шинээр 2162 ажлын байр бий болсон байна. Сум хөгжүүлэх сангийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор Зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн програм хангамжийг боловсруулан 2019 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээлэл оруулах эрхийг 331 суманд олгосноос 190 сум 5485 зээлдэгчийн холбогдох зээлийн мэдээллийг мэдээллийн санд нэгтгэв.	
4.8	МУТХҮБ-2030-ын 2.1.3, ЗГҮАХ-ийн 2.57 дахь заалт	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах Хөнгөн ҮБХЗГ	Ажлын явц, хувиар	30.0	130.0 Гадаад эх үүсвэр	0	Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулахаар үзэл баримтлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр бэлдээд байна. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийг байгуулахад чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд: 1. Засгийн газрын 73 дугаар тогтоолын дагуу арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой БХБ-ын Сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг Харгиа урьдчилсан цэвэрлэх байгууламж, Эмээлтийн үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхээр	40

							<p>төлөвлөж, ТЭЗҮ-ийг шинэчлэх үүргийг хотын захиргаанд өгөв. 2. ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, газрын дарга, мэргэжилтнүүд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан болон ажлын албаныхантай ажил хэргийн уулзалт /2019.05.14/ зохион байгуулж үйлдвэрлэл технологийн паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг ажлыг хурдацтай эхлүүлэх тал дээр хамтран ажиллахаар болов. 3. Барилга, хот байгуулалтын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар 2019/03, 2019/01, 01/07 тоот хамтран ажиллах санамж бичиг байгуулав /2019.10.07/.</p>	
4.9	<p>МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58 дахь заалт</p>	<p>Төрөөс дотоодын худалдан авалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх ЖДҮХБХЗГ</p>	<p>Дотоодын худалдан авалтын өсөлтийн хувь</p>	10.0	-	<p>- улсын төсөв 24.0</p>	<p>1. Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор дотооддоо үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай 155 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг баталлаа. Эдгээр бараа, бүтээгдэхүүнийг аливаа тендерийн үндсэн нөхцөл болгож, худалдан авах бодлогыг Засгийн газар баримтлахаар тогтсон. 2. Засгийн газраас үүрэг болгосны дагуу төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийг дэмжих нь эдийн засгийн хүндрэлээс гарахад бодитой хувь нэмэр оруулна гэж үзэж 2019 оны 4 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2019” үзэсгэлэнг “Мишээл экспо” үзэсгэлэнгийн танхимд зохион байгууллаа. Үзэсгэлэнд 150 орчим үндэсний үйлдвэрлэгчид төрийн худалдан авалтанд нийлүүлэх боломжтой стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээ дэлгэн үзүүлж, нөгөө талаас 70 орчим төрийн байгууллагууд энэ онд худалдан авах бараа бүтээгдэхүүний мэдээллийг нийтэд ил тод байршуулж оролцлоо.</p>	100